




ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ
2018.05.21-05.25

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын гол индексүүд харьцангуй тогтвортой байж бага зэргийн өсөлттэй хаагдав. S&P 500 индекст багтдаг эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш унасан. Урт хугацааны бондын өгөөж багасан, өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч компанийн ногдол ашиг хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж эхэлсэнээр тус компаниудын хувьцааны ханш өсжээ.

ОПЕК-ийн орнууд газрын тосны цаашдын үнийн өсөлтөөс сэргийлж 6-р сараас нийлүүлэлтээ ихэсгэнэ хэмээн мэдэгдсэнээр газрын тосны үнэ огцом унасан байна.

БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпиний Эдийн засгийн ахлах зөвлөх Лю Ху АНУ-д хийсэн айлчлалын үеэр БНХАУ-ын талаас АНУ-ын импортын өсөлтийг дэмжиж, худалдааны алдагдлыг нь 200 тэрбум ам.доллараар бууруулах санал тавьсан байна. Ийнхүү БНХАУ-ын 150 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнд ногдуулах тарифын шийдвэрээ АНУ түр хугацаанд хойшлуулахаар болов.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп БНАСАУ-ын удирдагч Ким Чен Унтай хийх уулзалтаа цуцалсан явдал АНУ-ын хувьцааны индексүүдийг бууруулав.

Холбооны нөөцийн сангийн бодлого зохицуулагчид инфляцийн зорилтот түвшинг 2%-д барина хэмээн мэдээлжээ.

Европ: Геополитикийн тодорхой бус байдал болон Европын эдийн засгийн сул үзүүлэлтүүд тус нутгийн компаниудын хувьцааны ханшийг ихээр хэлбэлзүүлсэн байна.

АНУ-ын авто машинуудын импортод тариф ногдуулна хэмээн мэдэгдсэнээр Европын компаниудын хувьцаануудын ханш унажээ.

Европын бүсийн Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 1 жилийн дотор хамгийн доод түвшинд хүрэв. Францын PMI 5-р сард огцом унаж сүүлийн 17 сарын хамгийн доод түвшинд хүрсэн бол Германы тус индекс сул хэвээр байна. Их Британийн инфляцийн түвшин доогуур байгаа бол жижиглэнгийн худалдаа ихэсчээ.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш уналттай хаагдав. Иенийн ханш ам. долларын эсрэг 109.25 хүрчээ.

АНУ-ын Засгийн газар импортын авто машинд 25 хувийн тариф ногдуулах асуудал авч хэлэлцсэнээр Японы авто машин үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш огцом буурсан байна. Toyota болон Honda компаниудын хувьцааны ханш 6%-аар унасан бол Nissan компанийн хувьцааны ханш 3 орчим хувиар буурчээ.

БНХАУ: АНУ-ын Ерөнхийлөгч Хойд Солонгосын тэргүүнтэй хийх уулзалтаа цуцалсан явдал Хятад улсын индекст сөргөөр нөлөөлөв.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,213.17	-0.21% ▼
Dow Jones	АНУ	24,715.09	-0.47% ▼
S&P 500	АНУ	2,712.97	-0.54% ▼
Nasdaq	АНУ	7,354.34	-0.66% ▼
S&P/TSX	Канад	16,162.31	1.27% ▲
FTSE 100	Их Британи	7,778.79	0.70% ▲
S&P/ASX 200	Австрали	6,087.40	-0.47% ▼
Nikkei 225	Япон	22,930.36	0.76% ▲
Hang Seng	Хонг Конг	31,047.91	-0.24% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.63
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	96.73
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.07
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.88
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.16
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.51
TDBM' 2020	USD	9.3%	106.29

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	ҮөҮ
Libor 1M	1.976	0.02 ▲
Libor 3M	2.318	-0.01 ▼
Libor 6M	2.482	-0.02 ▼
Libor 1YR	2.731	-0.03 ▼
US 6M Bond	2.064	-0.01 ▼
US 2YR Bond	2.476	-0.08 ▼
US 3YR Bond	2.608	-0.12 ▼
US 5YR Bond	2.765	-0.14 ▼
US 10YR Bond	2.931	-0.14 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.05.25	Өөрчлөлт
USD	2,410.82	0.21% ▲
CNY	377.23	-0.06% ▼
EUR	2,817.77	-0.85% ▼
RUB	39.09	0.64% ▲
KRW	2.23	-
JPY	22.04	1.61% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,302.25	0.71% ▲
Мөнгө /spot/	16.51	0.43% ▲
Зэс	307.75	0.46% ▲
Нүүрс	103.15	-0.91% ▼
WTI газрын тос	67.88	-4.77% ▼
Brent газрын тос	76.44	-2.64% ▼
Байгалийн хий	2.94	3.16% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.IV	6.00%
Бодлогын хүү	2018. IV	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. III	10.07%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. III	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. III	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. III	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. III	11.30%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 53 компанийн 628.9 сая төгрөгийн 5,186,503 ширхэг хувьцаа арилжигдав.


“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 74.83%-аар буюу хамгийн ихээр өсч 1,396 төгрөгт хүрч хаагдсан бол “Э-транс ложистикс” /ETR/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 85 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

Компанийн бонд хоёрдогч зах зээл дээр арилжигдаагүй байна.


5-р сарын 25-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,495.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,937.65 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 3.77%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	628.9
Зах зээлийн үнэлгээ	2,495,698.4

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,937.65	3.77% ▲
MSE I индекс	9,652.68	6.47% ▲
MSE II индекс	10,037.75	-1.50% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛендМН ББСБ	4,797,182	234,577,351
АПУ	235,183	142,463,164
Таван Толгой	7,734	75,681,500
Силк нет	72,164	52,282,818
Говь	1,662	36,129,660

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	1,396.00	74.83% ▲
Усжуулах	551.01	44.92% ▲
Айтүүлс	153.02	30.79% ▲
АПУ	650.08	15.18% ▲
Бинсэ	402.50	15.00% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Э-транс ложистикс	85.00	-15.00% ▼
Женко тур бюро	80.00	-14.89% ▼
Шивээ овоо	2,051.00	-12.98% ▼
Шарын гол	2,203.00	-11.88% ▼
Махимпекс	2,611.00	-6.75% ▼


Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	291,389,448
Голомт Капитал	153,893,768
Ти Ди Би Капитал	125,572,320
БиДиСек	117,514,196
Евразиа капитал монголиа	115,865,985

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	650.08	691,803
Таван толгой	10,020.00	527,705
МИК	10,510.00	217,655
Говь	22,000.00	171,625
Сүү	219.81	75,615

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



"Монгол базальт" ХК-ийн хоёрдогч зах зээлийн арилжаа 2018.05.28-нд эхэлнэ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК дээр 2018 онд хийгдэж буй хоёрдахь IPO болох "Монгол Базальт" ХК нь нийт хувьцааны 30% буюу 16,925,100 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс 05 дугаар сарын 23-ны өдрийн хооронд авч дууслаа.

"Монгол Базальт" ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 3,086 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 53,562,855 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг даруй 3.1 дахин давсан үзүүлэлт боллоо. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 1/2458 тоот албан бичгээр "Монгол Базальт" ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, тус компанийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрөл олгосон байна.

Эх сурвалж: MSE.mn

СЗХ: "Erdene Resource Development"-ийн МХБ-д давхар бүртгүүлэх хүсэлтийг зөвшөөрлөө

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа давхар бүртгүүлэхээр хүсэлт гаргасан Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" (TSX:ERD) -ийн 1.2 сая канад долларын үнийн дүн бүхий 4,000,000 ширхэг хүртэл энгийн хувьцааг бүртгэхийг зөвшөөрлөө. Харин давхар бүртгэх ажлыг гүйцэтгэгчээр нь "Бидисек" компани ажиллаж байна.

"Erdene Resource Development"-ийг давхар бүртгэснээр цаашид Монголд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын Хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниуд Монголын хөрөнгийн зах зээлд амжилттай орж ирэх жишиг болно гэдгийг Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай онцолсон юм.

"Erdene Resource Development" компани Монголд Баян хөндий, Алтан нар, Алтан арроу талбайд алт, зэсийн хайгуул хийж байна. Сүүлд тус компани "Алтан нар" төслийн талбайн таамаг нөөцийг 208 хувиар, боломжит нөөцийг 172 хувиар нэмэгдүүлж тогтоосноо зарласан юм. "Алтан арроу" төслийн талбайд хийж байгаа нэмэлт хайгуулаа 2018 онд дуусгахаар зорьж байгаа аж. Харин Баян хөндий талбайд хайгуулын ажлаа үргэлжлүүлж байгаа бөгөөд "North Midfield" бүсэд он гарснаас хойш зургаан өрөмдлөг хийсэн байна. Төлөвлөсний дагуу "Midfield", "Striker" бүсэд хайгуул хийж байгаа аж.

Улиралд тус компани хайгуулын зардлаа жилийн өмнөхтэй харьцуулахад 50 хувиар нэмэгдүүлж, 226.5 мянган канад доллар болгосон талаараа санхүүгийн тайландаа дурджээ. Хэдий тийм боловч алдагдлын хэмжээ нь 18 хувиар өсөж, 701 мянган канад доллар болсон байна.

Эх сурвалж: MSE.mn, BloombergTv.mn

СЗХ-ны ээлжит хуралдаан 5-р сарын 23-ны өдөр боллоо

"Ди Би Эм ассет менежмент ҮЦК" ХХК-ийн үүсгэн байгуулж буй "Үндэсний стратегийн хөрөнгө оруулалт", "Силк рөүд Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн үүсгэн байгуулж буй "Кинг Фанд" хувийн хөрөнгө оруулалтын сангуудын баримт бичгийг бүртгэлээ.

"Үндэсний стратегийн хөрөнгө оруулалт" сан нь нэг бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 500,000 ширхэг нэгж эрхээ хөрөнгө оруулагчид санал болгон 500 тэрбум төгрөгийн хөрөнгийг эхний нэг жилд татан төвлөрүүлэхээр сангийн дүрэм, хөрөнгө итгэмжлэн удирдах журмын төсөл болон бизнес төлөвлөгөөнд тусгажээ. Харин "Кинг Фанд" сан нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000,000 ширхэг доорх төрлийн нэгж эрхтэй бөгөөд хөрөнгө оруулалтын бүсэд байгаа багцын компаниудын олон төрлийн хөрөнгийг идэвхтэй удирдан зохион байгуулах замаар урт хугацааны хөрөнгө оруулалт хийн ашигтай ажиллаж, нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг хангаж ажилласнаар ирэх таван жилд 21 тэрбум төгрөг болгохоор төлөвлөсөн байна.

1996 оноос түрээсийн үйл ажиллагаа явуулж буй "Монгол шир" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийнхаа хэлбэрийг өөрчилж, хязгаарлагдмал хариуцлагатай компани болгохоор шийдвэрлэсэн байна. Иймд тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нэгэнт шийдвэр гаргасан тул нийтэд санал болгон гаргасан 275,360 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хаслаа. Хувьцааны нэг бүрийн үнийг 2,714 төгрөгөөр тогтоож, компанид өөрийн эзэмшлийн хувьцааг буцааж зарах боломжийг жижиг хувьцаа эзэмшигчдэд бүрдүүлэхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгов.

Эх сурвалж: FRC.mn

"Steppe Gold" Канадын Хөрөнгийн биржид IPO хийв

Торонтогийн Хөрөнгийн биржид Монголоос "Steppe Gold" компани IPO гаргаж, анхдагч зах зээлээс 25 сая канад доллар татан төвлөрүүлснээр хоёрдогч зах зээлийн арилжаагаа албан ёсоор нээлээ.

Энэ нь 6-8 жилийн дараа гаднын Хөрөнгийн биржид хийж байгаа Монголын анхны уул уурхайн IPO болж байгаа төдийгүй мөн Торонтогийн Хөрөнгийн бирж дэх энэ оны анхны уул уурхайн компанийн IPO болж байгаа ажээ. Тус компанийн зах зээлийн үнэлгээ дунджаар 80 сая канад доллартай тэнцэж байна. "Steppe Gold"-ийн хувьд Монгол дахь Алтан цагаан овоо төслийн талбай дээрээ энэ онд 20 мянган метрийн өрөмдлөг хийхээр төлөвлөж байгаа ажээ. Мөн энэ онд багтааж анхны олборлолтоо хийхээр зорьж байна. Харин Баянхонгор аймаг дахь Уудам хөндий төслийн талбайгаасаа алтны өндөр илэрц бүхий дөрвөн хэсгийг олж илрүүлсэн талаараа мэдээлсэн юм.

Эх сурвалж: MSE.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Шивээхүрэн боомтоор өдөрт 750-850 нүүрс тээврийн автомашин нэвтэрч байна

Дөрөвдүгээр сард Шивээхүрэн-Сэхэ боомтоор 1.56 сая тонн нь нүүрс БНХАУ-ын талд нийлүүлсэн нь сүүлийн 26 жилийн хамгийн өндөр дүн болсон талаар ӨМӨЗО-ы Эннээ хошууны боомт мэдээллээ. Сэхэ боомт нь "Торгоны зам"-ын эдийн засгийн бүслүүрийн хойд хэсгийн хөдөлгөөний чухал хэсэг газар гэдгийг sxcoal.com сайт онцолсон байна. Нарийнсухайтын бүлэг ордод олборлолт хийж буй компаниуд Шивээхүрэн-Сэхэ боомтоор нүүрсээ экспортолж байгаа юм. Тус боомтоор өдөрт 1500 автомашин нүүрс тээвэрлэн гарах боломжтой боловч одоогоор дунджаар 750-850 тээврийн хэрэгсэл нэвтэрч байна. Одоогоос сарын өмнө буюу дөрөвдүгээр сарын 23-нд БНХАУ-ын талтай тохиролцсоны дагуу цайны завсарлагагүйгээр боомтоор нүүрс нэвтрүүлэхэд өдөрт 1403 автомашин гарч байсан талаар Шивээхүрэн боомтын захиргаа мэдээллээ.

Гол экспортлогч компаниудаас "SouthGobi Sands" ХХК-ийн хувьд оны эхний дөрвөн сар орчмын хугацаанд нэг сая орчим тонн нүүрс экспортолжээ. Тус компани хоёр сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрээ байгуулсан бөгөөд энэ сард багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа аж. Харин МАК компани нэг сая тонн нүүрс угаах хүчин чадалтай үйлдвэрийнхээ барилгын ажлын 80 хувийг хийж гүйцэтгээд байгаа бол "Өсөх зоос" ХХК угаах үйлдвэрийнхээ барилгын ажлыг долоодугаар сард эхлэхээр төлөвлөж байгаа юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



ВI: БНХАУ-ын зах зээлд нүүрсний ханш өсөх төлөвтэй байна

БНХАУ-ын зах зээлд нүүрсний ханш ойрын хоёр сарын хугацаанд өсөх төлөвтэй байгаа гэж "Bloomberg Intelligence"-ийн шинжээчид таамаглаж байна. Учир нь Хубэй, Хунан, Жианси, Жижианг, Гуанси мужид тавдугаар сарын дундуур 35-аас дээш хэмийн халуун болох төлөвтэй байгаа, энэ хэрээрээ цахилгаан эрчим хүчний хэрэглээ огцом нэмэгдэнэ гэж тооцоолжээ. БНХАУ-ын гол зургаан цахилгаан станцын долоо хоногийн нүүрсний хэрэглээ нэмэгдсээр хоёрдугаар сараас хойших дээд түвшинд хүрсэн байна. Харин нүүрсний агуулахууд дахь нөөцийн хэмжээ сүүлийн гурван сарын хамгийн доод түвшинд очоод байгаа юм.

Үүнээс гадна энэ он гарснаас хойш "Hainan Mining Industry", "Henan Energy Group"-ийн нүүрсний ордуудад таван удаа томоохон осол гарсан байна. Үүнтэй холбоотойгоор БНХАУ-ын Засгийн газар аюулгүй байдал, байгаль орчны хяналтаа чангатгаж, тавдугаар сар гарснаас хойш хэд хэдэн уурхайг хаагаад байгаа ажээ. Энэ нь олборлолт буурах, цаашлаад зарим компанийн үйл ажиллагаагаа тэлэх бодлогыг хязгаарлаж байна. Оны эхний дөрвөн сард "Shenhua Energy"-ийн олборлолт 6.2 хувиар, "China Coal"-ийнх 4.2 хувиар тус тус буурчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БНХАУ: Дунд болон урт хугацаанд нүүрсний ханшийг 78-89 ам.долларт барина

Тавдугаар сарын 22-нд БНХАУ-ын Засгийн газраас "Shenhua Energy", "China Coal" зэрэг томоохон нүүрсний компаниудад 5500 ккалын илчлэгтэй нүүрсний ханшаа 93 ам.доллараас 89 ам.доллар болгож бууруулах үүрэг өгсөн байна. Үүнтэй холбоотойгоор "Zhengzhou" түүхий эдийн биржид нүүрсний ханш дөрвөн хувиар унаад байна. БНХАУ-ын Засгийн газраас нүүрсний ханшийг дунд болон урт хугацаандаа тонн тутам нь 78-89 ам.долларт барихаар тодорхой зохицуулалтуудыг хийж байгаа ажээ. Тухайлбал, 2018 оны эхний улиралд хууль, хяналтынхан нүүрсний үнэд хязгаарлалт тавьсан бөгөөд улмаар ханш нь бараг 25 орчим хувиар унаад байсан юм. Түүний дараа нүүрсний импортын хэмжээгээ хязгаарлаж өгснөөр БНХАУ-ын Засгийн газар ханшийг эргэн 16 орчим хувиар сэргээж чаджээ. Ийнхүү БНХАУ-ын Засгийн газар ханшийг тодорхой заагт барих бодлогыг хэрэгжүүлж байна.

Мөн нүүрсний ханшийг 119 ам.долларт хязгаарлаад байгаа юм. Тус улсын Засгийн газраас нүүрсний ханш 90 ам.долларыг давахад нүүрсний нөөцөө гурван өдрийн олборлолтоос их байлгаж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлагыг компаниудад тавиад байна. Харин ханш 78 ам.доллараас буурвал нүүрсний нөөцөө хамгийн багадаа долоон өдрийн олборлолтын хэмжээтэй тэнцүүлэн нэмэгдүүлж, улмаар нийлүүлэлтээ бууруулахыг шаардаж байгаа аж. Эдгээр зохицуулалтуудын дүнд 2018 онд БНХАУ-ын нүүрсний нийлүүлэлт нэг тэрбум тоннд хүрэх төлөвтэй байна. Мөн ханш нь харьцангуй тогтвортой байхыг "Bloomberg Intelligence"-ийн шинжээчид онцолж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ХААБ: 2017 онд 436.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан

Хөдөө аж ахуйн биржийг олон нийтэд нээлттэй хувьчлахаар Засгийн газар шийдвэрлээд байна. Урьдчилсан байдлаар ХААБ ХХК-ийн 49 хувийг хувьчлах хэрэгтэй гэж Засгийн газар үзжээ. ХААБ 2017 онд 1.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь төлөвлөснөөс 24 орчим хувиар давсан үзүүлэлт болсон байна. Ингэснээр тус бирж 2017 онд 436.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд анх удаа ашигтай ажилласан гэж ХААБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Баатар онцолж байсан юм. Тус бирж 2017 онд нийт 6.9 мянган тонн ноолуур, 10.9 мянган тонн хонины ноос гэх мэт түүхий эдийг арилжиж, нийт 572 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна. 2018 он гарснаас хойш таван сарын хугацаанд 285.8 тэрбум төгрөгийн түүхий эд арилжаад байгаа юм. Өнөөдрийн байдлаар ХААБ-д брокерын зургаан компани зуучлалын үйл ажиллагаа явуулж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



БУСАД МЭДЭЭ

ЗГ: Төрийн банк, Хөрөнгийн бирж, МИАТ зэрэг компанийг хувьчилна

Засгийн газрын хуралдаанаар “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр боллоо.

Төсөлд тусгаснаар Төрийн банк, Монголын Хөрөнгийн бирж, МИАТ, “Монголын цахилгаан холбоо”, “Мэдээлэл, холбооны сүлжээ”, “Хөдөө аж ахуйн бирж” зэрэг компаниудыг хувьчлахаар төлөвлөсөн байна. Тухайлбал, эрчим хүч, автозам, уул уурхай, банк, санхүү, мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн өмчит, өмчийн оролцоотой 18 байгууллагыг бүрэн, 19-ийнх нь тодорхой хувийг хувьчлахаар төлөвлөжээ. Сангийн сайдын мэдээлснээр Төрийн банкныг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хувьчлах, мөн стратегийн хөрөнгө оруулагчид тодорхой хувийг нь хувьчлах байр суурьтай байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

2019 оны төсвийн алдагдлыг ДНБ-ий 6.1 хувьтай тэнцэхээр баталлаа

УИХ-ын чуулганы хуралдаанаар 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг баталлаа. 2019 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 8.8 их наяд төгрөг, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг найман хувьд хүргэхээр баталсан байна.

Харин төсвийн зарлага 10.9 их наяд төгрөг, төсвийн алдагдал 2.1 их наяд төгрөг байхаар баталжээ. Энэ нь 2018 батлагдсан төсөвтэй харьцуулахад алдагдлыг 300 тэрбум төгрөгөөр багасгасан үзүүлэлт болж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гэж заасан боловч хуульд нэмэлт өөрчлөлт орсоор өнөөгийн алдагдлын түвшин дотоодын нийт бүтээгдэхүүний зургаан хувьд хүрээд байна. Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг үнэлэх ажлын хэсэг төсвийн зөвлөл байгуулах болон бүтцийн өөрчлөлтийн бодлого удаашралтай байна гэж дүгнэж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Монголбанк: Шууд хөрөнгө оруулалт өссөн нь төлбөрийн тэнцлийн алдагдал буурахад дэм болсон

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн алдагдал энэ оны гуравдугаар сард 23 сая ам.доллараар буурч, 42.2 сая ам.доллар болсон гэж Монголбанк мэдээллээ.

Төлбөрийн тэнцлийн алдагдал буурахад Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт өссөн нь голчлон нөлөөлжээ. 2018 оны эхний улиралд Монгол Улсад цэвэр дүнгээр 465.2 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Хэдий тийм боловч урт хугацаагаар нь авч үзвэл гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 32.6 тэрбум ам.долларын алдагдалтай байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

World Economics: Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс 4 сар дараалан өсөв

Тавдугаар сард Монголын борлуулалтын менежерүүдийн индекс огцом өсөж, 63.4 нэгж болсон талаар “World Economics” байгууллага мэдээллээ. Ингэснээр индекс сүүлийн дөрвөн сар дараалан өсөлттэй гарч байгаа аж. 2018 оны эхний улирлын байдлаар эдийн засгийн өсөлт эрчимжиж, 6.1 хувьд хүрээд байгаа юм. Үүнээс гадна 2018 он гарснаас хойш бизнесийн итгэлийн индекс өсөлтийн бүсэд хадгалагдаж байгаа ч бараа, үйлчилгээний үнэ тавдугаар сард огцом өссөнийг “World Economics” байгууллагын тайлангаас харж болохоор байна. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр инфляц дөрөвдүгээр сарын байдлаар зургаан хувьтай, өмнөх саруудынхтай харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан юм. Монголбанкны үзэж байгаагаар инфляц энэ онд зорилтот түвшин болох найм орчим хувьд тогтворжих төлөвтэй байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



АНУ-ын Төв банкны бодлогын болзошгүй нөлөө ба Монгол Улс

АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогоо чангатгах нь Ази, Номхон далайн улсын банкнуудад төдийлөн сөргөөр нөлөөлөхгүй гэж “Fitch” агентлаг шинээр гаргасан тайландаа дурджээ. Хэдий тийм боловч гадаад өр, хөрөнгө оруулалтын хэмжээ нь өндөр байгаа орнуудын зээл болон хөрвөх чадварт эрсдэл үүсэхээр байгааг “Fitch” агентлаг анхааруулсан байна. Ялангуяа гадаад валютын ханшнаас өндөр хамааралтай Шри-Ланка болон Монгол зэрэг улсын банкны салбарт дарамт учруулахаар байгаа юм байна. Харин Хонгконг, Сингапур зэрэг санхүүгийн төвүүдэд нөхцөл байдал харьцангуй сайн ч хөрөнгө оруулалтын орчинд савлагаа үүсэж болзошгүй гэж шинжээчид тооцоолжээ.

“Fitch” агентлагийн мэдээлснээр АНУ-ын Холбооны Нөөцийн банк 2019 оны эцэс гэхэд бодлогын хүүгээ 3.25 хувь болгож өсгөх төлөвтэй байгаа юм. 2004-2006 онд Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ нэг хувиас 5.25 хувь болгон өсгөхөд Ази, Номхон далайн бүсийн орнуудын банкны салбарт тодорхой сөрөг нөлөө мэдрэгдэж байжээ. Үүнээс хойш бүсийн банкны салбар “Basel 3” зэрэг олон улсын стандартыг нэвтрүүлснээр тогтвортой өсөлтөө хадгалах боломж бүрдээд байгааг “Fitch”-ийн шинжээчид онцолж байна.

Эх сурвалж: NSO.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.